



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2025 оны 07 сарын 08 өдөр

Дугаар 382

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1, 6.4.2, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны харьяа газруудын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 4 нэрийн, нийт 483,240,000.00 (дөрвөн зуун наян гурван сая хоёр зуун дөчин мянга) төгрөгийн балансын үнэ, 356,750,000.00 (гурван зуун тавин зургаан сая долоон зуун тавин мянга) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий автомашинуудыг хавсралтад заасны дагуу балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Уртнасан, яамны харьяа байгууллагын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын цахим систем"-д бүртгэх;

2.3.Тогтоолын биелэлтийг 2025 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл) -г үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ



Төрийн эмчийн бодлого, зохицуулалтын газрын
2025 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн
... дугаар тогтоолын хавсралт

БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМНЫ ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН
ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)	Шинээр бүртгэх авах үнэ	Ашиглах жил	Хүлээн авах байгууллага
1	Lexus LX 570-J200 /07- 08УНБ/	2015.02.15	ш	1	215,000,000.00	215,000,000.00	-	30,000,000.00	3	Хан хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа
2	Ланд 200 /УАА 74-55/	2019.07.28	ш	1	179,000,000.00	89,500,000.00	89,500,000.00			Цаг уур, орчны шинжилгээний газар
3	AZERA /УНУ 04-38/	2012.06.06	ш	1	48,140,000.00	48,140,000.00	-	3,000,000.00	2	Байгаль орчны хэмжил зүйн төв лаборатори
4	УАЗ.220695-550 /УНВ 31-54/	1905.07.13	ш	1	41,100,000.00	4,110,000.00	36,990,000.00			Байгаль орчны судалгаа, шинжилгээний төв УТУГ
				4	483,240,000.00	356,750,000.00	126,490,000.00			
Нийт дүн					(дөрвөн зуун наян гурван сая хоёр зуун дөчин мянга)	(гурван зуун тавин зургаан сая долоон зуун тавин мянга)	(нэг зуун хорин зургаан сая дөрвөн зуун ерэн төгрөг)			